



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 31

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 20 дугаар зүйлийн 20.1.11 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тайшир сумын 12 жилийн бүрэн дунд сургуулийн өнөөгийн нөхцөл байдалтай танилцаж, цаашид сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг сайжруулж, шинэлэг агуулга хэлбэрээр зохион байгуулах талаар дүгнэлт, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Мөнхтөр /ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Нарийн бичгийн дарга: С.Цагаанбаатар /Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн/

Гишүүдэд: Р.Батмөнх /Боловсрол, соёлын газрын дарга/

Ц.Сэвжид /Хан-Тайшир Эрдэм цогцолбор сургуулийн захирал/

Б.Цэдэвсүрэн /Тайшир сумын Засаг дарга/

Ш.Даваасүрэн /Тайшир сумын сургуулийн захирал/

М.Болдбаатар /Дэлхийн зөн ОУБ-ын аймаг дахь хөтөлбөрийн захирал/

3. Сургалтын агуулга, чанар стандартыг сайжруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах талаар оновчтой санал боловсруулан 2017 оны 05 дугаар сарын 15-ны дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг /А.Мөнхтөр/-т даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ